

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/129/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: .70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежерийн үүргийг
түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг: injig78@yahoo.com
Аудитор: Б.Отгон-Өлзий
Утас: 99844655 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
	2.1. Оршил.....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
	2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	8
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
	2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
	2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
	2.13. Шилэн дансны мэдээлэл.....	11
	2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	11
	2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БИЕИЙН
ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА
Г.БАТЛХАМ ТАНАА

2020.02.28 № 1-6/158
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Батлхам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 сарын 28-ны өдрөөс 2020 оны 01 сарын 29-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 сарын 29-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ийн аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020

оны 01 дүгээр сарын 28-ны өдөр-ны өдрийн 13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын эрхэм зорилго нь Нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, иргэдийн биеийн тамирч, спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлэх, оюун санаа бие бялдрын хөгжлийг хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газар нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 546,500.1 мянган төгрөгөөс тооцон 10,930.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 975,197.4 мянган төгрөгөөр буюу 51.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс

материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	10,710.0	0.0	10,710.0
Урьдчилгаа			
Бараа материал	87,867.6	98,624.0	-10,756.4
Үндсэн хөрөнгө	1,969,166.5	3,098,408.6	-1,129,242.1
Нийт хөрөнгө	1,879,685.1	2,919,866.5	-1,037,181.3
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,879,685.1	2,919,866.5	-1,037,181.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,879,685.1	2,919,866.5	-1,037,181.3

Авлага дансны үлдэгдэл буурсан нь тус байгууллагын өмнөх оны давсан орлогыг төсөвт төвлөрүүлснийг буцаан авч тайлант онд авлага барагдуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аж ахуйн материалын үлдэгдэл 11,771.4 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Энэ өсөлт Усан бассейн ашиглалтад орж фитнес ажиллуулж эхэлсэнтэй холбоотой ашиглалтад байгаа эргэлтийн хөрөнгө буюу аж ахуйн материал худалдан авсантай холбоотой байна. Бараа материалын үлдэгдэлд 2019 онд ашиглалтад орсон биеийн тамир спорт цогцолборын барилгын зураг төсвийн үнэ 51,238.6 мянган төгрөгийг 2017 онд бүртгэсэн байна. Энэ тус барилгын өртөг орсон эсэхийг хянах буюу материалын үнийн хий өсгөж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд Усан бассейн улсын төсвийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулснаас шалтгаалжээ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,118,412.1 мянган төгрөг Усан бассейны барилга баригдсан байна. Тус барилга ашиглалтад орсноор Саранхөхөө театраас 1,980.0 мянган төгрөгийн 2 ширхэг гэрлийн пушик балансаас балансад шилжүүлэн авсан, тоног, төхөөрөмж 3,330.0 мянган төгрөгөөр, тавилга хэрэгсэл 5,520.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,919,866.5 мянган төгрөг болж 1,037,181.3 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газар тайлант онд 10,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 13,440.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 134.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого төгрөг/

/мянган

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	10,000.0	13,440.1	3,440.1	134.4
Нийт дүн	10,000.0	13,440.1	3,440.1	134.4

Үндсэн үйл ажиллагааны орлого 3,440.1 мянган төгрөгөөр давсан нь шинээр үйл ажиллагааны төрөл нэмэгдэж Усан бассейн, фитнесийн үйлчилгээ үзүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 361,811.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 100 хувь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 351,811.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 13,440.1 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газар 2019 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдсан Усан бассейн ашиглалтад орж фитнес ажиллуулснаар үндсэн үйл ажиллагааны 13,440.1 мянган төгрөгийн орлого оруулж батлагдсан төсвийн дагуу зарцуулсан байна.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй зэрэгцүүлэн судалгаа хийлээ Үүнд.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,203.5	180,186.0	17.5	100.0
НДШ-ийн зардал	22,525.4	22,116.0	409.4	98.2
Гэрэл, цахилгаан	7,208.9	9,393.8	-2,184.9	130.3
Түлш, халаалт	88,475.6	88,475.6	0.0	100.0
Цэвэр, бохир ус	21,648.0	19,154.5	2,493.5	88.5
Бичиг хэрэг	360.0	359.6	0.4	99.9

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тээвэр, шатахуун	3,000.0	2,999.9	0.1	100.0
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	840.0	1,036.1	-196.1	123.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500.0	303.9	196.1	60.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000.0	1,000.0	0.0	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300.0	299.9	0.1	100.0
Урсгал засвар	3,000.0	2,999.9	0.1	100.0
Дотоод албан томилолт	1,700.0	1,608.3	91.7	94.6
Бараа үйлчилгээний бусад зардал	30,000.0	29,997.7	2.3	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,050.0	1,050.0	0.0	100.0
Төвлөрүүлэлт		4,270.1	-4,270.1	
Нийт зардлын дүн	361,811.4	365,251.3	-3,439.9	101.0

Дээрхи судалгааны хүснэгтээс харахад шуудан холбооны зардал 196.1 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардал 2,184.9 мянган төгрөгөөр тус тус хэтэрч цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, хог хаягдал зайлуулах зардал, дотоод албан томилолтын зардал 17.5-2,493,5 мянган төгрөгөөр хэмнэж нийт зардал 830.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Судалгаанаас харахад материаллаг дүнтэй хэлбэлзэл бүхий зардал гараагүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тухайн байгууллагад төсөв батлагдаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 365,251.5 мянган төгрөг буюу 101.0 хувьтай байгаа нь орлогын төлөвлөгөөг 34.4 хувь буюу 3,440.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн тайлагнасан холбоотой байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 22,713.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13,340.0 мянга, урьд оны үлдэгдлээс 10,710.0 мянга нийт 46,763.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс гэрэл цахилгааны зардалд 2,35.2 мянга, бичиг хэргийн зардалд 300.0 мянга, шуудан холбоо интернетийн төлбөрт 100.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс 19,279.8 мянга, багаж, техник хэрэгсэлд 3,330.0 мянган төгрөг, тавилга худалдан авахад 5,5520.0 мянга, урсгал засварт 3,998.9 мянга, бараа ажил үйлчилгээний зардалд 11,300.0 мянга нийт 46,763.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 1 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 0 эрсдэл тодорхойлж нийт 1 горим сорил хэрэгжүүллээ.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус газрын 2019 онд ашиглалтад орсон цогцолборын барилгын зураг төсвийн үнэ 51,238.623 төгрөгийг 2017 онд материалд бүртгэсэн байна. Энэ нь цогцолборын барилгын анхны өртөгт тусгагдан бүртгэсэн эсэхийг тодруулж, материалын үлдэгдлээс хассан эсэхийг хянах

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 116 мэдээллийг хугацаанд нь, 32 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 0 мэдээллийг байршуулаагүй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 29,290.7 мянган төгрөгийн зөрчилд 23.3 төлбөрийн акт тогтоосноос 23.3 мянган төгрөгийг барагдуулсан, 29,267.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 29,267.4 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>98,577,622.26</u>	<u>98,624,022.26</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30.00	30.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	30.00	30.00
3121	Төгрөг	30.00	30.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	30.00	30.00
33	АВЛАГА	10,710,000.00	00.00
335	Бусад авлага	10,710,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	10,710,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	87,867,592.26	98,623,992.26
354	Хангамжийн материал	87,867,592.26	98,623,992.26
35410	Бичиг хэргийн материал	340,800.00	385,800.00
35420	Аж ахуйн материал	86,466,792.26	98,238,192.26
35440	Түлш, шатах тослох материал	1,060,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,781,107,509.01</u>	<u>2,818,242,445.36</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,781,107,509.01	2,818,242,445.36
392	Биет хөрөнгө	851,347,509.01	1,888,482,445.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	902,029,606.00	2,020,441,703.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-114,036,592.68	-191,378,157.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,486,992.81	76,796,992.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	-29,447,023.00	-40,353,258.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,098,882.54	70,618,882.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-43,790,356.66	-47,649,716.70
39217	Ном	6,000.00	6,000.00
393	Биет бус хөрөнгө	929,760,000.00	929,760,000.00
39301	Програм хангамж	785,000.00	785,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-785,000.00	-785,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	929,760,000.00	929,760,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,879,685,131.27</u>	<u>2,916,866,467.62</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,879,685,131.27</u>	<u>2,916,866,467.62</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,879,685,131.27	2,916,866,467.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,367,588,204.56	1,367,588,204.56
51101	Өмч: - төрийн	1,367,588,204.56	1,367,588,204.56
512	Хуримтлагдсан үр дүн	134,829,115.66	1,172,010,452.01
51210	Өмнөх үеийн үр дүн	134,829,115.66	134,829,115.66
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,037,181,336.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	377,267,811.05	377,267,811.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,879,685,131.27</u>	<u>2,916,866,467.62</u>

/Төгрөгөөр/

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	378,911,104.00	1,521,697,452.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,510,850.00	1,133,832,152.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,510,850.00	1,133,832,152.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,510,850.00	1,133,832,152.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,764,500.00	13,440,055.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,746,350.00	1,120,392,097.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,480,254.00	36,053,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	291,920,000.00	351,811,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,480,254.00	36,053,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,412,850.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,800,000.00	13,340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,267,404.00	22,713,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	390,651,602.47	484,516,115.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	390,651,602.47	484,516,115.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	371,624,662.47	479,196,012.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,101,621.00	180,186,024.00
210101	Үндсэн цалин	119,101,621.00	163,598,589.00
210102	Нэмэгдэл	00.00	9,289,002.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	7,298,433.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,112,472.00	22,115,985.00
210201	Тэтгэврийн даатгал	9,559,235.00	15,420,245.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,186,201.00	1,798,507.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	948,957.00	1,438,807.00
210204	Ажилгүйдлийн даатгал	213,328.00	314,403.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,204,751.00	3,144,023.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,922,795.00	119,959,170.00
210301	Гэрэл, цахилгаан	3,103,357.00	12,329,058.00
210302	Түлш, халаалт	65,099,216.00	88,663,555.00
210303	Цэвэр, бохир ус	23,720,222.00	18,966,557.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,812,424.00	14,602,489.07
210401	Бичиг хэрэг	3,945,410.00	582,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,938,125.00	4,059,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	843,009.00	1,136,102.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	520,000.00	303,857.07
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,565,880.00	8,520,530.00

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	1,930,650.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,930,650.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,054,746.85	7,319,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	532,000.00	00.00
210602	Тавилга	1,246,916.85	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	299,900.00
210604	Урсгал засвар	16,275,830.00	7,019,250.00
2107	Томилолт, зочны зардал	995,500.00	1,608,300.00
210702	Дотоод албан томилолт	995,500.00	1,608,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	193,600.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	193,600.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,500,853.62	133,404,894.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,156,262.00	41,297,734.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,344,591.62	92,107,160.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,026,940.00	5,320,102.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	486,150.00	1,050,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	486,150.00	1,050,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,540,790.00	4,270,102.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,540,790.00	4,270,102.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-11,740,498.47	1,037,181,336.35
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,856,545.33	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	207,176.97	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	3,649,368.36	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-3,856,545.33	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-15,597,043.80	1,037,181,336.35

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>376,215,934.00</u>	<u>412,015,355.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,815,680.00	13,440,055.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,815,680.00	13,440,055.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,764,500.00	13,440,055.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,764,500.00	13,440,055.00
120009	Бусад орлого	3,051,180.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	357,400,254.00	398,575,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	291,920,000.00	351,811,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,480,254.00	46,763,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,412,850.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,800,000.00	13,340,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,267,404.00	33,423,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>339,123,622.00</u>	<u>403,165,355.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	339,123,622.00	403,165,355.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	319,718,682.00	397,845,252.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,051,621.00	180,186,024.00
210101	Үндсэн цалин	119,051,621.00	159,796,460.00
210102	Нэмэгдэл	00.00	10,885,518.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	9,504,046.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,508,472.00	22,115,985.00
210201	Тэтгэврийн даатгал	9,328,797.00	15,420,245.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,812,639.00	1,798,507.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	948,957.00	1,438,807.00
210204	Ажилгүйдлийн даатгал	213,328.00	314,403.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,204,751.00	3,144,023.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,134,095.00	119,959,170.00
210301	Гэрэл, цахилгаан	3,334,357.00	12,329,058.00
210302	Түлш, халаалт	62,079,516.00	88,475,631.00
210303	Цэвэр, бохир ус	23,720,222.00	19,154,481.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,931,072.00	25,379,239.07
210401	Бичиг хэрэг	1,360,000.00	659,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,998,125.00	2,999,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	843,009.00	1,136,102.00

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	520,000.00	303,857.07
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,209,938.00	20,279,780.00
2105	Нормативт зардал	2,000,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,966,310.00	7,298,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,659,000.00	00.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	299,950.00
210604	Урсгал засвар	15,307,310.00	6,998,850.00
2107	Томилолт, зочны зардал	995,500.00	1,608,300.00
210702	Дотоод албан томилолт	995,500.00	1,608,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,131,612.00	41,297,734.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,131,612.00	41,297,734.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,404,940.00	5,320,102.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	864,150.00	1,050,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	864,150.00	1,050,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,540,790.00	4,270,102.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,540,790.00	4,270,102.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>37,092,312.00</u>	<u>8,850,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	37,092,282.00	8,850,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,092,282.00	8,850,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	37,092,282.00	8,850,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,092,282.00	8,850,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-37,092,282.00</u>	<u>-8,850,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	30.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	30.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30.00	30.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	437,828,204.56	285,768,229.00	63,184,690.82	786,781,124.38
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	171,778.00	171,778.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	437,828,204.56	285,768,229.00	63,356,468.82	786,952,902.38
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-34,606,468.23	-34,606,468.23
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,367,588,204.56	377,267,811.05	134,829,115.66	1,879,685,131.27
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,367,588,204.56	377,267,811.05	134,829,115.66	1,879,685,131.27
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,367,588,204.56	377,267,811.05	134,829,115.66	1,879,685,131.27
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,037,181,336.35	1,037,181,336.35
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,367,588,204.56	377,267,811.05	1,172,010,452.01	2,916,866,467.62

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	306,127,500.00	307,684,500.00	361,811,400.00	365,251,455.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	306,127,500.00	307,684,500.00	361,811,400.00	365,251,455.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,127,500.00	299,853,710.00	360,761,400.00	359,931,352.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,052,000.00	119,051,621.00	180,203,500.00	180,186,024.00
210101	Үндсэн цалин	119,052,000.00	119,051,621.00	159,814,000.00	159,796,460.00
210102	Нэмэгдэл	00.00	00.00	10,885,500.00	10,885,518.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00	9,504,000.00	9,504,046.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,832,700.00	14,508,472.00	22,525,400.00	22,115,985.00
210201	Тэтгэврийн даатгал	14,188,500.00	9,328,797.00	15,419,300.00	15,420,245.00
210202	Тэтгэмжийн даатгал	728,000.00	1,812,639.00	1,776,500.00	1,798,507.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	911,100.00	948,957.00	1,421,200.00	1,438,807.00
210204	Ажилгүйдлийн даатгал	182,200.00	213,328.00	355,300.00	314,403.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,822,100.00	2,204,751.00	3,553,100.00	3,144,023.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,197,500.00	89,134,095.00	117,332,500.00	117,023,950.00
210301	Гэрэл, цахилгаан	5,587,900.00	3,334,357.00	7,208,900.00	9,393,838.00
210302	Түлш, халаалт	53,018,600.00	62,079,516.00	88,475,600.00	88,475,631.00
210303	Цэвэр, бохир ус	29,591,000.00	23,720,222.00	21,648,000.00	19,154,481.00
210304	Байрны түрээс	00.00	00.00	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,700,000.00	5,689,854.00	5,700,000.00	5,699,459.07
210401	Бичиг хэрэг	360,000.00	360,000.00	360,000.00	359,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	2,998,125.00	3,000,000.00	2,999,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	840,000.00	843,009.00	840,000.00	1,036,102.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	520,000.00	500,000.00	303,857.07
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	968,720.00	1,000,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,137,800.00	39,267,310.00	3,300,000.00	3,299,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00	00.00	00.00

**Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2019 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210602	Тавилга	15,000,000.00	11,360,000.00	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00	300,000.00	299,950.00
210604	Урсгал засвар	13,137,800.00	12,907,310.00	3,000,000.00	2,999,950.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	995,500.00	1,700,000.00	1,608,300.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	995,500.00	1,700,000.00	1,608,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31207500.00	31206858.00	30000000.00	29997734.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,207,500.00	31,206,858.00	30,000,000.00	29,997,734.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	1050000.00	1050000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	00.00	1,050,000.00	1,050,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	1,050,000.00	1,050,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	306,127,500.00	307,684,500.00	361,811,400.00	365,251,455.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	291,920,000.00	291,920,000.00	351,811,400.00	351,811,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	291,920,000.00	291,920,000.00	351,811,400.00	351,811,400.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,207,500.00	15,964,500.00	10,000,000.00	13,440,055.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,207,500.00	15,764,500.00	10,000,000.00	13,440,055.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	00.00	00.00	12.00	22.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	07.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	04.00	10.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	00.00	00.00

4.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				30
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		68,531,404.00		46,763,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		68,531,404.00		46,763,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		56,957,254.00		46,763,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал				2,935,220.00
210301	Гэрэл, цахилгаан				2,935,220.00
2104	Хангамж, бараа материалын зардал		3,241,218.00		19,679,780.00
210401	Бичиг хэрэг		1,000,000.00		300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр				100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,241,218.00		19,279,780.00
2105	Нормативт зардал		2,000,000.00		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		2,000,000.00		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал				12,848,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл				3,330,000.00
210602	Тавилга				5,520,000.00
210604	Урсгал засвар				3,998,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		29,924,754.00		11,300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		29,924,754.00		11,300,000.00
	Олгосон санхүүжилт шилжүүлэг		10,710,000.00		
	Төвлөрүүлэх шилжүүлэг		10,710,000.00		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		65,480,254.00		46,763,900.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого		65,480,254.00		46,763,900.00
	Засаг даргын нөөц сангаас		8,412,850.00		36,053,900.00
	Дээд шатны төсөв захирагчаас		27,800,000.00		13,340,000.00
	Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		29,267,404.00		33,423,900.00